



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 291

Улаанбаатар хот

Төлөөлөгчийн газрыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын хохирол үнэлэгч “Хас үнэлгээ” ХХК-д Өмнөговь аймгийн Цогтцэций сум, төв Их ус 1-1а тоотод нэг, Дорноговь аймгийн Сайншанд сум, “Монгол шуудан” ХК-ийн байранд нэг, нийт хоёр төлөөлөгчийн газар нээснийг бүртгэсүгэй.

2. Төлөөлөгчийн газар нээх болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Хас үнэлгээ” ХХК /Л.Нямбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН